



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 73

Арвайхээр

Арвайхээр цэцэрлэгжилт Орон нутгийн
өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
Удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Арвайхээр Цэцэрлэгжилт" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 6.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Арвайхээр цэцэрлэгжилт Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Удирдах зөвлөлийн дарга: Ц.Эрдэнэсүрэн (Арвайхээр сумын Засаг даргын орлогч)

Гишүүд: Ю.Ганхуяг(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ойн нэгжийн дарга)

Н.Нацагням (сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Ө.Золбаяр (хотын Захирагчийн албаны ногоон байгууламж хариуцсан

мэргэжилтэн)

Б.Гал-Эрдэнэ (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

2. Арвайхээр Цэцэрлэгжилт Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дагаж мөрдөх журам, жилийн ажлын төлөвлөлт, норм, нормативыг тогтоох эдийн засгийн бодит тооцоо судалгаа хийх, үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж, төсвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр тогтмол хангаж ажиллахыг Удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Арвайхээр цэцэрлэгжилт Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Удирдах зөвлөл байгуулах тухай" 2021 оны 18 дугаар тогтоолыг 2021 оны 12 сарын 28-наас хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ДОНЬДДОРЖ